Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

БАТЛАВ
ДОТРЫН АНАГААХ СУДЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭН
.........................................
Ц.САРАНТУЯА

# ДОТРЫН АНАГААХ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, 3-аас цөөнгүй судалгааны бүтээлийг нийтлүүлсэн байх /нэгдүгээр зохиогчоор 1-ээс цөөнгүй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн/;
3. Дотрын зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээг гардан гүйцэтгэх мэдлэг, ур чадвар эзэмшсэн байх;
4. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллагын хэмжээнд мэргэжлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхитай, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд хувь нэмэр оруулсан талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэгч байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гардан хийж, сүүлийн 5 жилд нэгдүгээр зохиогчоор 2-оос цөөнгүй бүтээлийг мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх;
3. Дотрын зонхилон тохиолдох өвчний хүндрэл болон дотрын ховор тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээг гардан гүйцэтгэх мэдлэг, ур чадвар эзэмшсэн байх;
4. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллагын хэмжээнд мэргэжлийн

5. чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхитай, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд хувь нэмэр оруулсан талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;
6. Дотрын анагаах ухааны оношилгоо шинэ, шинэлэг арга, технологиос суралцан, эзэмшиж, үр дүнд хүрсэн тухай товч, тодорхой мэдээлэл ирүүлсэн байх;
7. Төгсөлтийн дараах сургалтад "Удирдагч багш"-аар ажиллаж, 2-оос цөөнгүй эмч, эмнэлгийн мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
8. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачилгатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
9. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийсэн эсвэл төслийн багт хамтран ажилласан, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх ба үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн (нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх) байх;
3. Дотрын анагаах ухааны оношилгоо, эмчилгээний шинэ, шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, мэргэшлийн чиглэлээр оношилгоо, эмчилгээний баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/ байх;

   Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт тайлан ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэшлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхитай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;
4. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтад удирдагч багшаар ажиллаж, 3-аас олон мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;

5. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачилгатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
6. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
7. Дотрын анагаахын чиглэлээр оношилгоо, эмчилгээний дараах ур чадварыг эзэмшсэн байх: Үүнд:

<u>Бөөр судлалын чиглэлээр</u> шинжилгээ, эмчилгээний өвөрмөц аргуудад үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай байх /бөөрний биопси, Kt/V, PET шинжилгээ, бөөрний изотоп, такролимусын тун тодорхойлох, кортикостеройд ба дархлаа дарангуйлах эмчилгээ, гемодиализ ба хэвлийн диализ, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний өмнө ба дараах менежментийг удирдах чадвартайг нотолсон албан байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт ирүүлэх/;
<u>Дотоод шүүрэл судлалын чиглэлээр</u> шинжилгээ, эмчилгээний өвөрмөц аргуудад үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай байх /бамбайн хэт авиа, изотоп шинжилгээг үнэлэх, даавврын шинжилгээг дүгнэх, эмийн эмчилгээний заалт, архаг өвчний хяналт, урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх чадвартайг нотолсон албан байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт ирүүлэх/;
<u>Зүрх судас судлалын чиглэлээр</u> шинжилгээ, эмчилгээний өвөрмөц аргуудад үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай байх /зүрхний хэт авиа, зүрхний ачаалалтай сорил, холтер мониторинг, зүрх судасны инвазив болон инвазив бус эмчилгээний заалт гаргах, хэрэглэх ур чадвартайг нотолсон албан байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт ирүүлэх/;
<u>Ревматологи судлалын чиглэлээр</u> шинжилгээ, эмчилгээний өвөрмөц аргуудад үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай байх /үений рентген шинжилгээ, иммунологийн шинжилгээний заалт, эмчилгээний заалт, сэргээн засах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх чадвартайг нотолсон албан байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт ирүүлэх/;
<u>Уушги судлалын чиглэлээр</u> шинжилгээ, эмчилгээний өвөрмөц аргуудад үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай байх /гуурсан хоолой өдөөх сорил, гуурсан хоолойн дуран, цээжний хэт авиан түргэвчилсэн үнэлгээ; инвазив болон инвазив бус аргаар амьсгал удирдах, сэргээн засах, урьдчилан сэргийлэх технологийг хэрэглэх ур чадвартайг нотолсон албан байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт ирүүлэх/;
<u>Хоол боловсруулах судлалын чиглэлээр</u> шинжилгээ, эмчилгээний өвөрмөц аргуудад үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай байх /хэвлийн эрхтний дүрс оношилгоо, ходоод, гэдэс, цөсний замын дуран, үйл оношийн шинжилгээ, эмгэг бүтэц зүйн шинжилгээ, эмийн эмчилгээ, хавдрын эрт илрүүлэг, эрт үеийн хавдрын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх чадвартайг нотолсон байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт ирүүлэх/;
<u>Цус судлалын чиглэлээр</u> шинжилгээ, эмчилгээний өвөрмөц аргуудад үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай байх /цусны гистограмм, ясны хэмийн эсийн шинжилгээ, гемистазиограммын шинжилгээг дүгнэх, цус цусан бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэх, бай эмийн эмчилгээний заалтыг гаргах ур чадвартайг нотолсон албан байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт ирүүлэх/.

**Бөөр судлал**

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Бөөр судлалын оношилгоо, эмчилгээний дараах ур чадварыг эзэмшсэн байх: бөөрний биопси, Kt/V , PET шинжилгээ, бөөрний изотоп, такролимусын тун тодорхойлох, кортикостеройд ба дархлаа дарангуйлах эмчилгээ, гемодиализ ба хэвлийн диализ, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ г.м;
2. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
3. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээлийг мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх ба үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/ байх;
4. Бөөр судлалын оношилгоо, эмчилгээний шинэ, шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэшлийн баримт, бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/ ;
5. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэшлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхитай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;
6. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтад “Удирдагч багш”-аар ажиллаж, 3-аас олон мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
7. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачилгатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
8. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх.

**Дотоод шүүрэл судлал**

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;

2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх ба үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн байх /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/;
3. Дотоод шүүрэл судлалын оношилгоо, эмчилгээний шинэ, шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааны эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/ ;
4. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэжлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтад “Удирдагч багш”-аар ажиллаж, 3-аас олон мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачилгатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Дотоод шүүрэл судлалын оношилгоо, эмчилгээний гардан ур чадвар /бамбайн биопси, хэт авиа, изотоп шинжилгээ, даврын шинжилгээг дүгнэх, эмийн эмчилгээний заалт, өвчний хяналт, урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх чадвартайг нотолсон албан байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт ирүүлэх/ эзэмшсэн байх.

**<u>Зүрх судлал</u>**

<u>ЗӨВЛӨХ</u> зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх ба үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/ байх;
3. Зүрх судас судлалын оношилгоо, эмчилгээний шинэ, шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааны

эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/ байх;

4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт, ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэжлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтанд "Удирдагч багш"-аар ажиллаж, 3-аас олон мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачилгатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Зүрх, судас судлалын оношилгоо, эмчилгээний мэргэшсэн, зүрхний хэт авиа, зүрхний ачаалалтай сорил, холтерийн мониторинг шинжилгээг хийж, дүгнэлт өгөх ур чадвартай байх.

**Ревматологи**

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх ба үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн байх /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/;
3. Ревматологийн оношилгоо, эмчилгээний шинэ, шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/;
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэжлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхтай,

тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;

5. Сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй дараах сургалтад "Удирдагч багш"-аар ажиллаж, 3-аас олон мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачилгатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Ревматологийн чиглэлээр оношилгоо, эмчилгээний гардан ур чадварыг эзэмшсэн байх.

**Уушги судлал**

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх бА үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/ байх;
3. Уушги судлалын оношилгоо, эмчилгээний шинэ, шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/;
9. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэжлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/; Сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй дараах сургалтанд "Удирдагч багш"-аар ажиллаж, 3-аас олон мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
10. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд

манлайлалтай, идэвхи санаачилгатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
11. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
12. Уушги судлалын чиглэлээр оношилгоо /уушгины дүрс оношилгоо, эмгэг бүтэц зүйн шинжилгээ, гуурсан хоолой өдөөх сорил, гуурсан хоолойн дуран, дурангийн тусламжтай хийх гардан ажилбар, цээжний хэт авиан түргэвчилсэн үнэлгээ, хэт авиан хяналтан дор хийх гардан ажилбар/, эмчилгээ /инвазив болон инвазив бус аргаар амьсгал удирдах/,сэргээн засах, урьдчилан сэргийлэх аргыг эзэмшсэн байх.

**<u>Хоол боловсруулах тогтолцоо судлал</u>**

<u>ЗӨВЛӨХ</u> зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх ба үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн байх /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/;
3. Хоол боловсруулах тогтолцоо судлалын оношилгоо, эмчилгээний шинэ, шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/;
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэжлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтад "Удирдагч багш"-аар ажиллаж, 3-аас дээш мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачилгатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх ;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Хоол боловсруулах тогтолцоо судлалын чиглэлээр шинжилгээний өвөрмөц аргуудад үнэлгээ, дүгнэлт өгөх /хэвлийн эрхтэний дүрс оношилгоо, эмгэг бүтэц зүйн шинжилгээ/, шинжилгээг гардан хийх чадвартай /хэвлийн хэт

авиа ба элэгний биопси хатгалт, ходоод, гэдэс, цөсний замын дуран, үйл оношийн шинжилгээний аль нэгийг гардан гүйцэтгэдэг/, эмнэлзүйн эм судлал, хавдрын эрт илрүүлэг, эрт үеийн хавдрын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга эзэмшсэн байх.

**<u>Мэргэжлийн шалтгаант өвчин судлал</u>**

<u>ЗӨВЛӨХ</u> зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллага /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/-аас зохион байгуулсан мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийсэн эсвэл төслийн багт хамтран ажилласан,сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх ба үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/ байх;
3. Мэргэжлийн шалтгаант өвчин судлалын оношилгоо, эмчилгээний шинэ шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, мэргэжлийн чиглэлээр оношилгоо, эмчилгээний баримт, бичиг, бодлого боловсруулах багт ажиллах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/;
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэжлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтад удирдагч багшаар ажиллаж, 3-аас цөөнгүй мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайллалтай, идэвхи санаачлагатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Мэргэжлийн шалтгаант өвчин судлалын чиглэлээр оношилгоо, эмчилгээ, хяналт, урьдчилан сэргийлэх өвөрмөц аргуудад үнэлгээ дүгнэлт өгөх чадвартай, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ур чадварыг эзэмшсэн байх;
9. Хөдөлмөрийн эрүүл ахуйн суурь сургалтыг 40 ба түүнээс дээш цаг дүүргэсэн, хөдөлмөрийн нөхцөлийн эрсдэлд хүчин зүйл /дуу шуугиан, доргион, тоос, химийн бодис г.м/ түүнээс шалтгаалсан өвчлөлийн эмнэлзүйн

ур чадварыг эзэмшсэн, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд үнэлэлт, дүгнэлт, санал зөвлөмж өгөх ур чадварыг эзэмшсэн байх;

10. "Хөдөлмөрийн тухай хууль", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль", "Нийгмийн даатгалын тухай хууль" болон бусад холбогдох хууль эрх зүйн мэдлэгтэй, мэргэжлээс шалтгаалах өвчтэй даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх суурь мэдлэгтэй байх.

**Настан судлал**

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллага /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/-аас зохион байгуулсан мэргэжил, мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийсэн эсвэл төслийн багт хамтран ажилласан, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байх ба үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн байх /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/;
3. Настан судлалын оношилгоо, эмчилгээний шинэ шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, мэргэжлийн чиглэлээр оношилгоо, эмчилгээний баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал/;
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, бүс, үндэсний хэмжээнд мэргэжлийн чиглэлээр зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хөгжилд өөрийн хувь нэмэр, мэдлэг ур чадвараа дайчлан гар бие оролцсон талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/;
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд мэргэшсэн настны эмч, сувилагч бэлтгэх төгсөлтийн дараах сургалтад удирдагч багшаар ажиллаж, 3-аас цөөнгүй мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд хүн амын эрүүл насжилт, настны эрүүл мэндийн чиглэлээр нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачлагатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Настанд зонхилон тохиолдох өвчний эмгэг болон хам шинжийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх;

9. Настны чиглэлээр ажиллаж буй байгууллагуудтай хамтран ажиллаж, настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан байх.

**Спортын анагаах ухаан судлал**

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллага /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/-аас зохион байгуулсан мэргэжил, мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ,судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж,сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 2-оос цөөнгүй бүтээл мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байна. Үүнээс 1-2 бүтээлийг олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх / байх;
3. Спортын анагаах судлалын оношилгоо, эмчилгээний шинэ шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал,шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл оновчтой санал/ ;
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, үндэсний хэмжээнд зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулсан талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/ ;
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтад удирдагч багшаар ажиллаж, 3-аас цөөнгүй мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачлагатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Спортын физиологи, тамирчдад зонхилон тохиолддог дотор өвчин судлалын өвчнүүдийн оношилгоо, эмчилгээ болон спортын төрөл бүрд тохирсон хоол зүйн мэдлэгтэй байх; спортын практикт хэрэглэдэг сорил шинжилгээнд үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай байх /зүрх судас, амьсгалын тогтолцооны үйл ажиллагааны байдлыг тодорхойлох сорилууд: үүнд: хүчилтөрөгчтэй болон хүчилтөрөгчгүй орчинд ажиллах чадварыг тодорхойлох сорилууд Штангийн, Вангатын, PWC-170 сорил, Гарвардын сорил, Сүүний хүчил тодорхойлох, зүрхний энгийн болон ачаалалтай бичлэгт үнэлэлт дүгнэлт өгөх/;

9. Олимпийн их наадам болон Тив дэлхий, Олон улсын тэмцээн уралдаанд Монгол улсын баг тамирчдын эрүүл мэндийг хариуцан ажилласан туршлагатай байх.

**Эмнэл зүйн хордлого судлал**

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллага /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/-аас зохион байгуулсан мэргэжил, мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээлийг мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байна. Үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн байх /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/;
3. Эмнэл зүйн хордлого судлалын оношилгоо, эмчилгээний шинэ шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ,сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал) ;
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, үндэсний хэмжээнд зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулсан талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/ ;
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтад удирдагч багшаар ажиллаж, 3-аас цөөнгүй мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачлагатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Эмнэл зүйн хордлого судлалын оношилгоо, эмчилгээний ур чадварыг эзэмшсэн (хорт бодисуудыг тодорхойлох аргууд, антидот эмчилгээ, цус цэвэршүүлэх аргууд болох гемодиафильтраци, ультрафильтраци, гемосорбци, гемооксигенаци, плазмосорбци, гемофильтраци, лимфосорбци, гялтангийн диализ, плазмаферез, плазмафильтраци, цус озонжуулалт, энтросорбент эмчилгээ, даралтат хүчилтөрөгчийн эмчилгээ, хор үүсгэгчийг тандах, үнэлэх, мэдээлэх, хордлоготой тэмцэх, сургалт сурталчилгаа хийх, зохион байгуулах үйл ажиллагаа зохицуулах зэрэг) байх.

**Цус судлал**

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллага /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/-аас зохион байгуулсан мэргэжил, мэргэшлийн чиглэлийн 1-2 багц цагийн сургалтад жил бүр хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг бие даан хийж, сүүлийн 8 жилийн хугацаанд нэгдүгээр зохиогчоор 4-өөс цөөнгүй бүтээлийг мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байна. Үүнээс 1-2 нь олон улсын ном, сэтгүүлд нийтлүүлсэн эсвэл хэлэлцүүлсэн байх /нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, зохиогчийн эрх/;
3. Цус судлалын оношилгоо, эмчилгээний шинэ шинэлэг технологиос эмнэлзүйн практикт нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан анагаах ухааныг эмнэлзүйд ашиглах, төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ,сэргээн засах, урьдчилан сэргийлэх чиглэлээр баримт, бичиг, бодлого боловсруулах чадвартай байх /эмнэлзүйн заавар, удирдамж, гардан үйлдлийн стандарт зэрэг мэргэжлийн баримт бичиг боловсруулах багийг удирдсан эсвэл ажлын хэсэгт хамтран ажилласан, санал, шүүмж, оюуны өмч, патент, шинэ бүтээл, оновчтой санал) ;
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан, байгууллагын тодорхойлолт ирүүлсэн байх /байгууллага, орон нутаг, үндэсний хэмжээнд зөвлөх, багаар ажиллах чадавхтай, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулсан талаар байгууллагаас өгсөн тодорхойлолтод тусгасан байх/ ;
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтад удирдагч багшаар ажиллаж, 3-аас цөөнгүй мэргэжилтэнг дагалдуулан сургасан байх;
6. Сүүлийн 5 жилд нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан зохион байгуулсан ажлын эсвэл олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлалтай, идэвхи санаачлагатай оролцсон талаарх тодорхойлолт ирүүлсэн байх;
7. Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
8. Цус судлалын мэргэшлийн 15 жилээс доошгүй жил ажилласан байх.